



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/137

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1.3, 15 дугаар зүйлийн 1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Титэм” Ерөнхий боловсролын сургуулийн сурагч Э.Энх-Үжин нь АНУ-ын Нью-Йорк хотод зохион байгуулагдах олон Улсын хөгжмийн наадмын Гала тоглолтод оролцох зардалд 2,000,000 (Хоёр сая) төгрөг, Жүдо бөхийн “Хоймор нутаг” холбооны баг тамирчид Өвөрхангай аймгийн Хар хорин суманд зохион байгуулагдах Хангайн бүсийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох зардалд 1,600,000 (Нэг сая зургаан зуун мянга) төгрөг, Рашаант сумын уугуул Т.Цагаач нь Монгол Улсын гавьяат механикжуулагч цолоор шагнагдсанд хүндэтгэл үзүүлж 2,000,000 (Хоёр сая) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх дэмжлэгийн 5,600,000 (Таван сая зургаан зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн) -т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ